



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Г Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг  
шинэчлэн бүртгэх тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-ийн “Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал”-ын хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэсүгэй.
2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “… Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Практикал даатгал” ХХК /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.
3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Практикал даатгал” ХХК /Э.Баярмагнай/, актуарч /Н.Цэрэнлонжид/ нарт тус тус анхааруулсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.





**Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл**

1.	Даатгалын компанийн нэр:	“Практикал даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	“Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал”
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгалын баталгаанд нэр заагдсан хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд байна.
5.	Даатгалын эрсдэл	<p>Даатгуулагч дор дурдсан эрсдэлийн улмаас бэртэх, гэмтэх, нас барах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн эрсдэл:           <ol style="list-style-type: none"> <li>1. Зөвхөн үндэсний баяр наадмаар хурдан морины уралдаан, түүний бэлтгэл, сунгааны үед / Морь малнаас унах, чирэгдэх, дайруулах, өшиглүүлэх, хазуулах, мөргүүлэх/</li> <li>3. Нэмэлт эрсдэл (1) /нэмэлт хураамж төлсөн тохиолдолд хамаарна/               <ol style="list-style-type: none"> <li>1. Бусад уралдаан түүний бэлтгэл, сунгааны үед / Морь малнаас унах, чирэгдэх, дайруулах, өшиглүүлэх, хазуулах, мөргүүлэх/</li> </ol> </li> <li>4. Нэмэлт эрсдэл (2) /Хурдан морини уралдаанаас бусад үеийн гэнэтийн осол /нэмэлт хураамж төлсөн тохиолдолд хамаарна/</li> </ol> </li> </ol>
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	15 бүлэг, 72 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 19-020/52 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Актуарч Н.Цэрэнлонжид
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгалын газрын захирал Э.Баярмагнай, даатгалын мэргэжилтэн М.Баттөмөр